

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ТӨСЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь чухал ашигт малтмалын төсөлд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Чухал ашигт малтмалын төслийг дэмжих хууль тогтоомж

2.1.Чухал ашигт малтмалын төслийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“бизнесийн таатай орчин” гэж төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгө, газар, хүний нөөц, дэд бүтэц, нийтийн хэрэгцээг хангах болон ажиллагсдын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн орчныг;

3.1.2.“дэмжих дэд бүтэц” гэж судалгаа хөгжүүлэлт, бизнес эрхлэлтийг дэмжих, техникийн болон мэргэжлийн сургалтын зориулалтаар ашиглах, төсөл хэрэгжүүлэгч, төр, өмчийн бусад этгээдийн хамтын ажиллагааг дэмжих байгууламжийг;

3.1.3.“нөлөөлөлд өртөх бүс” гэж уурхайн эдэлбэр газар, овоолго ба чулуулаг хадгалах талбай, үйлдвэр, химийн бодис, түлш хадгалах агуулах, хаягдал усны сан болон ус дамжуулах хоолой, усан сан, олборлолтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дэд бүтэц, замын сүлжээ, ажилчдын кемп, төслийн хаягдлын далангаас гадагш 10 км-ын радиуст хамаарч байгаа орон зайг;

3.1.4.“нөлөөлөлд өртөх хүн” гэж төслийн үйл ажиллагааны улмаас эд хөрөнгө, эрүүл мэнд, орлого, амьдралын хэв маяг нь өөрчлөгдөх, нөлөөлөлд өртөх бүсэд амьдарч, эсхүл тухайн бүсийг эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаандаа ашиглаж буй хүнийг;

3.1.5.“чухал ашигт малтмал” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.32-т заасныг;

3.1.6.“төсөл хэрэгжүүлэгч” гэж чухал ашигт малтмалын төслийг хэрэгжүүлэхээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авсан, эсхүл гэрээ байгуулсан этгээд болон уг төсөлд хөрөнгө оруулж, төслийн үйл ажиллагаанаас үр өгөөж хүртэх этгээдийг;

4 дүгээр зүйл.Чухал ашигт малтмалын төслийг дэмжихэд баримтлах зарчим

4.1.Чухал ашигт малтмалын төслийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.хууль дээдлэх, бизнесийн ёс зүйг эрхэмлэх;
- 4.1.2.хөгжлийн бодлогод нийцсэн, ирээдүйн хөгжлийг дэмжсэн байх;
- 4.1.3.үр өгөөжтэй байх;
- 4.1.4.байгаль орчин, хүний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй байх;
- 4.1.5.ил тод, нээлттэй байх;
- 4.1.6.бизнесийн таатай орчныг бүрдүүлсэн байх;
- 4.1.7.олон талын оролцоог хангасан байх;
- 4.1.8.тогтвортой байх;
- 4.1.9.хүн төвтэй байх;
- 4.1.10.дэвшилтэт технологид суурилсан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ТӨСӨЛ, БҮРТГЭЛ

5 дугаар зүйл.Чухал ашигт малтмалыг тодорхойлох

5.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь чухал ашигт малтмалын төрлийг тодорхойлж, Засгийн газарт хүргүүлнэ.

5.2.Чухал ашигт малтмалын төрлийн жагсаалтыг Засгийн газар батална.

6 дугаар зүйл.Чухал ашигт малтмалын төслийг бүртгэх

6.1.Чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэх этгээдийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.

7 дугаар зүйл.Чухал ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

7.1.Чухал ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг төсөл хэрэгжүүлэгчийн өргөдөлд үндэслэн олгоно.

7.2.Чухал ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад чухал ашигт

малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргахдаа дараах асуудлын талаар санал боловсруулж хүргүүлнэ:

7.2.1.чухал ашигт малтмалын үр өгөөжийн хэлбэрийг тодорхойлох;

7.2.2.орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг төслийн шаардлагад нийцүүлэн чадавхжуулах санал;

7.2.3.төсөл хэрэгжүүлэгчид үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох;

7.2.4.төсөлд ажиллах хүний нөөцийг сургаж, технологи шилжүүлэх, инновац нэвтрүүлэх;

7.2.5.нөлөөлөлд өртөх хүний судалгааг хийж, түүнийг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ҮР ӨГӨӨЖ БА ТӨСӨЛД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

8 дугаар зүйл. Чухал ашигт малтмалын үр өгөөж

8.1.Чухал ашигт малтмалын үр өгөөж нь дараах хэлбэртэй байна:

8.1.1.ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр;

8.1.2.төсөлд хөрөнгө оруулах замаар хүртэх ногдол ашиг;

8.1.3.анхны хөрөнгө оруулалтаа нөхсөн төслөөс хүртэх ашиг;

8.1.4.нийтийн зориулалттай болон дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт;

8.2.Төсөл хэрэгжүүлэгч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутагтай хамтран чухал ашигт малтмалын төслийн талаарх танилцуулгыг нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, төслийн үр өгөөжийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлаар санал авна.

8.3.Чухал ашигт малтмалын үр өгөөжийг дараах журмаар тодорхойлж, төвлөрүүлнэ:

8.3.1.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 7.2.1-д заасан үр өгөөжийн талаарх саналыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

8.3.2.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 8.3.1-д заасан саналыг эдийн засаг хөгжлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан үр өгөөжийг дараах хувь, хэмжээгээр тооцно:

8.4.1.энэ хуулийн 8.1.1-д заасан үр өгөөжийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлд тодорхойлсны дагуу;

8.4.2.энэ хуулийн 8.1.2-т заасан үр өгөөжийн хувьд төрөөс оруулсан хөрөнгийн хувиар;

8.4.3.энэ хуулийн 8.1.3-т заасан үр өгөөжийн хувьд төслийн анхны хөрөнгө оруулалтыг нөхөж дууссаны дараагийн жилийн цэвэр ашгаас 10 хувиар.

8.5.Төсөл хэрэгжүүлэгч нь бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөнд нийцүүлэн нийтийн зориулалттай болон дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх замаар энэ хуулийн 8.1.4-т заасан үр өгөөжийг төвлөрүүлж болно.

8.6.Энэ хуулийн 8.5-д заасан дэд бүтцийн санхүүжилтийн дүнгээс хамаарч нэг төслийг хэд хэдэн чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгч болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлдвэрлэгч нар хамтран хэрэгжүүлж болно.

8.7.Энэ хуулийн 8.5-д заасан дэд бүтцийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэх этгээдийг санхүүжилтэд оролцсон талууд хамтран сонгон шалгаруулж, гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавина.

8.8.Энэ хуулийн 8.5-д заасан дэд бүтцийн санхүүжилтэд төрөөс нэмэлт санхүүжилт гаргасан нь тухайн бүтээн байгуулалтын нийт зардлын 50 хувиас хэтрэхгүй бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Чухал ашигт малтмалын төслийн дэмжлэг

9.1.Чухал ашигт малтмалын төсөлд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дараах дэмжлэгийг үзүүлнэ:

9.1.1.боловсрол, сургалт, үйлдвэржилтийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих;

9.1.2.аж ахуйн нэгжийн чадавхыг дэмжих;

9.1.3.технологи ба инновацыг дэмжих;

9.1.4.санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;

9.1.5.газар, дэд бүтцийн дэмжлэг үзүүлэх;

9.1.6.дотоодын зах зээлийг хамгаалах;

9.1.7.гадаад худалдаа, экспортыг дэмжих;

9.1.8.гадаадын шууд хөрөнгө оруулалт татах;

9.1.9.олон улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан дэмжлэг эдлэх хүсэлтийг чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан гаргана.

9.3.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох хүсэлтийг нэгтгэн, асуудал хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

10 дугаар зүйл.Орон нутгийн дэмжлэг

10.1.Төсөл хэрэгжүүлэгч чухал ашигт малтмалын эрэл, хайгуул хийх, олборлолт явуулах, боловсруулалт хийх, үйлдвэр барих, газар, усны нөөц ашиглахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

10.2.Төсөл хэрэгжүүлэгчийн хуулиар олгогдсон ашигт малтмал хайх, ашиглах талбайтай давхардуулан бусдад газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгохгүй.

10.3.Энэ хуулийн 10.1-т заасан дэмжлэгийг үзүүлэхгүй бол геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь орон нутгийн захиргаанаас асуудлыг тодруулах, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанд асуудлыг танилцуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

11 дүгээр зүйл.Ил тод байдал ба тайлагнал

11.1.Чухал ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төслийн хэрэгжилтийн талаар жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан дараах агуулгаар олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар мэдээлнэ:

11.1.1.чухал ашигт малтмалын төслөөс тухайн жилд олборлосон, боловсруулсан, экспортод гаргасан болон дотоодын үйлдвэрт нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, ашигт малтмалын төрөл, орлого, зардал, ногдуулсан болон төлсөн татварын нэр төрөл;

11.1.2.чухал ашигт малтмалын үр өгөөжийн хэлбэр болон Үндэсний баялгийн санд төвлөрүүлсэн хэмжээ;

11.1.3.нөлөөлөлд өртөх хүний талаар авсан арга хэмжээний талаар;

11.1.4.ажилчдын эрүүл мэндийн үзлэг болон мэргэжлээс шалтгаалах өвчний талаар статистик мэдээлэл;

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

12 дугаар зүйл.Зөрчил, хариуцлага

12.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

13.1.Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалт:

“4.1.32. “чухал ашигт малтмал” гэж өндөр технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг;”

2/20¹ дугаар зүйл:

“20¹ дугаар зүйл. Чухал ашигт малтмал хайх талбай ялгах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох

20¹.1. Чухал ашигт малтмалын хайгуул хийх боломжтой талбайг геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ялгана.

20¹.2. Энэ хуулийн 20¹.1-т заасан талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой байдлаар ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хуваана.

20¹.3. Чухал ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох боломжтой талбайн мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулна.

20¹.4. Засгийн газрын шийдвэрийг үндэслэн чухал ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өргөдлөөр олгоно.”

3/47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалт:

“47.1.4. ашигт малтмал дотоодын зах зээлд худалдсан этгээд;”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “эзэмшигч” гэсний дараа “түүний үүсмэл орд эзэмшигч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах зүйл, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

“4.1.12.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”

2/5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:

“5.3.Ашигт малтмалын ард түмэнд ногдох үр өгөөжийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хэлбэрээр тодорхойлж, хэрэгжүүлнэ.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт:

“9.1.4.чухал ашигт малтмалын төрлийг батлах;”

4/47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн 1 дэх мөр:

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтын түвшингээс хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс (Cu)	тн	Зэс /цэвэр металлаар/	0-5000 хүртэл	0.00	0	0.00
				5000-6000 хүртэл	22.0	1.0	1.00
				6000-7000 хүртэл	24.0	2.0	2.00
				7000-8000 хүртэл	26.0	3.0	3.00
				8000-9000 хүртэл	28.0	4.0	4.00
				9000 ба түүнээс дээш	30.0	5.0	5.00

5/47² дугаар зүйл:

“47² дугаар зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

47².1.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордоос олборлон экспортолсон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нь энэ хуулийн 47.5, 47.17-д заасны дагуу ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн 100 хувьтай тэнцүү байна.

47².2.Чухал ашигт малтмалын ордоос олборлон экспортолсон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нь энэ хуулийн 47.5, 47.17-д заасны дагуу ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн 50 хувьтай тэнцүү байна.

47².3.Стратегийн ач холбогдол бүхий ордын үүсмэл ордоос олборлон экспортолсон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нь энэ хуулийн 47³.1-д заасны дагуу ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийн 100 хувьтай тэнцүү байна.

47².4.Энэ хуулийн 47.5-д заагаагүй чухал ашигт малтмалын ордоос олборлон экспортолсон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нь 2 хувь байна.

4 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны” гэснийг “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэснийг “нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн “үнэ төлбөргүйгээр” гэснийг хассугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“11.1.2.д. Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3-т заасан үр өгөөж.”

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “зөвшөөрөл эзэмшигч” гэсний дараа “, түүний үүсмэл ордыг эзэмшигч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.в дэд заалтын “47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын” гэснийг “47² дугаар зүйлд заасан” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “этгээд” гэснийг “этгээдийн төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсгийн “төвлөрүүлнэ.” гэснийг “төвлөрүүлэх эсхүл уг дүнгээр банкны баталгаа гаргуулж болно.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.20 дахь заалт нэмсүгэй:

“15.1.20. Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн 8.1.4-т заасан зориулалтаар гаргасан зардал;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй:

“14/чухал ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын зориулалтаар ашиглах эрхтэй газрын төлбөрийг хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанд, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэлх хугацаагаар.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмсүгэй:

“33.9.Ашигт малтмал хайх, ашиглах зорилгоор олгогдсон талбайтай давхардуулан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.8 дахь заалт нэмсүгэй:

“3.3.8. Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн 8.8-д заасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын худалдан авах ажиллагаа.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2.5 дахь заалт нэмсүгэй:

“3.2.5.Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн 8.8-д заасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 10.31 дүгээр зүйл нэмсүгэй:

“10.31 дүгээр зүйл.Геологи, уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанд хууль бусаар халдах

1.Геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хууль бусаар халдаж, тоног төхөөрөмж эвдсэн, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулсан, зам, уурхайн гарц хаасан, цахилгаан хангамж, усан хангамжийг зориуд тасалсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлээс болж үйлдвэрлэл 24 цагаас дээш тасалдсан, эсхүл эдийн засгийн ноцтой хохирол учирсан бол хүнийг нэг мянган зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “10.28” гэсний дараа “, 10.31” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалтын “борлуулсан” гэснийг “Монголбанк, түүний эрх олгосон арилжааны банканд тушаасан” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалтын “эцсийн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь заалтын “10 хувийг” гэснийг “30 хувийг” гэж, мөн хэсгийн “аймаг, улсын зэрэглэлтэй хотод” гэснийг “суманд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “ашигт малтмалын” гэсний дараа “болон чухал ашигт малтмалын” гэж нэмсүгэй”.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9 дэх хэсгийн “ашигт малтмалын” гэсний дараа “болон чухал ашигт малтмалын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.7 дахь заалтын “ашигт малтмалын” гэсний дараа “болон чухал ашигт малтмалын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----